

ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 5 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Зарим хүмүүсийг Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулах тухай, Орон нутгийн өмчийн асуудлууд, Ажлын хэсэг байгуулах тухай. /Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах ажлын хэсэг/, Ажлын хэсэг байгуулах тухай. /Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар бодлого боловсруулах/ тухай асуудлуудыг тус тус хэлэлцэн батлав.

Бусад ажлын хүрээнд:

Өсвөр насны хүүхэд, залууст цахим орчин дахь гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон гэр бүлээ хамгаалах, нийгмийн сүлжээний зүй зохистой хэрэглээг бий болгох зорилгоор "ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ЗӨВ ХЭРЭГЛЭЭ" сэдэвт эссэ бичлэгийн уралдаан зарласан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ГХУСАЗСЗ-өөс өсвөр насны хүүхэд залууст цахим орчин дахь гэмт хэрэг, зөрчил эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон гэр бүлээ хамгаалах, нийгмийн сүлжээний зүй зохистой хэрэглээг бий болгохоор зорилгоор “Цахим орчин дахь зөв хэрэглээ” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан зарласан ба тус уралдаанд нийт 46 сурагчид эссэ ирүүлсэн байна.

Эдгээрээс:

Тэргүүн байранд 1 дүгээр сургуулийн 11в ангийн сурагч С.Цолмон /40 оноогоор/
Дэд байранд Хан-Уул цогцолбор сургуулийн 11б ангийн сурагч Б.Одонцацрал /38 оноогоор/

Гутгаар байранд Хан-Уул цогцолбор сургуулийн 10а ангийн сурагч Э.Чинхүслэн /37 оноогоор/

Тусгай байранд 8 дугаар сургуулийн 10а ангийн сурагч Б.Мөнхбагана /36 оноогоор/
нар шалгарлаа.

Уралдаанд идэвхтэй хамрагдсан бүх сурагчиддаа баярлалаа!

“Цахим орчин дахь зөв хэрэглээ” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан нь сурагчдын цахим орчны талаарх мэдлэг ойлголтыг илрүүлсэн, цахим орчин дахь ёс зүйн хэм хэмжээг тодорхойлсон, цаашид хэрэгжүүлэх ажлын арга зүйг тодорхойлсон, бүтээлч үйл ажиллагаа байлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Дорнод аймгийн Санхүүчдийн Холбоотой хамтран аймаг, сумын түвшинд Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулж байгаа эсэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсын мэдээллийг ашиглан иргэдэд хяналт үнэлгээ шинжилгээ хийх чадварыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

ОРОН НУТАГТ ШИНЭ ТЕХНОЛОГИ БОЛОН НОГООН ТЕХНОЛОГИЙГ ДЭМЖИХ ТӨСЛИЙН 2 ДУГААР ШАТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЦАХИМААР ЯВАГДЛАА

Орон нутагт шинэ технологи болон ногоон технологийг нэвтрүүлж, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор Үндэсний хөгжлийн газар болон GIZ ЭТИС хөтөлбөр аймгийн ИТХ-ын дэргэдэх “Тогтвортой хөгжил - Түншлэл” зөвлөл хамтран “Шинэ технологийн” болон “Ногоон технологийн” чиглэлийн төслүүдийг 2020 оны 01 дүгээр 15-наас 03 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл хүлээн авч сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна

Дорнод аймгаас 5 аж ахуйн нэгж байгууллага төсөл ирүүлсэн ба нэгдүгээр шатанд “Онхоодой” ХХК, “Учрал хийц” ХХК, “Дорнын оргил” ХХК-ий төсөл шалгаран 2 дугаар шатны шалгаруулалтын ярилцлагыг цахимаар зохион байгууллаа

Шалгарсан төслүүдэд 30 хүртэл сая төгрөгийн тоног төхөөрөмжийг буцалтгүйгээр дэмжлэг олгох юм

“АРХИГҮЙ ИРЭЭДҮЙ ГОЁ” АЯН ЭХЭЛЛЭЭ

Урин дулаан цаг ирсэнтэй холбоотойгоор иргэд салхинд гарах, бөөгнөрөл үүсгэх, ахуйн хүрээнд буюу гэртээ, эсхүл хөдөө хээр архидаг согтуурсны улмаас маргалдаж бусдыг зодож хохирол учруулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг зөрчил өсч болзошгүй байна.

Тиймээс Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ГХУСАЗСЗ, аймгийн Залуучуудын Холбоо, Хэвлэл мэдээллийн байгууллагууд хамтран “Архигүй ирээдүй ГОЁ” аяныг эхлүүлж байна.

Аяны зорилго бол аймгийн ИТХ-аас баталсан “Архигүй Дорнодчуудын төлөө” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэн, нийгэм, гэр бүл, хамт олны дунд архины хэрэглээг бууруулах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, архидаг согтуурсны улмаас хүн амын эрүүл мэнд, нийгэмд учрах сөрөг үр дагаварыг багасгах, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх юм.

Энэхүү аяны хүрээнд Цахим орчинд “Архигүй ирээдүй ГОЁ” давалгаа challenge үүсгэх, архидаг согтуурахаас урьдчилан сэргийлэх, эерэг хандлагыг бий зорилгоор “Постер КОНТЕНТ”-ын уралдаан, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах, архины хамааралтай хүн, түүний гэр бүлд мэргэжлийн байгууллагын хүмүүсээр хууль эрх зүй, эрүүл мэнд, гэр бүлийн асуудлаар зөвлөгөө өгөх, архины хор хөнөөлийг сурталчилсан масктай ЭВЕНТ болон бусад ажлууд зорион байгуулагдана.

АРХИНААС ТАТГАЛЗАЖ БҮХ ХАЙРАА ГЭР БҮЛДЭЭ ЗОРИУЛЦГААЯ
“АРХИГҮЙ ИРЭЭДҮЙ ГОЁ”

Хоёр. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн Засаг даргын 2014 оны А/445 дугаар захирамжаар баталсан “Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны тайлан боловсруулах, түүнийг үнэлж дүгнэх журам”-ын дагуу нийт 24

агентлаг, 14 сумын 2019 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гарсан дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа.

ГУРАВ. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТАЛААР:

ТӨСВИЙН ОРЛОГЫН ТАЛААР:

Орон нутгийн нийторлого 35668.0 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 33751.6 сая төгрөг, үүнээс татварын орлого 7826.7 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 8240.3 сая төгрөгт хүрч 413.6 сая төгрөгөөр давж, татварын бус орлого 27841.3 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 25511.3 сая төгрөгт хүрч 2330.1 сая төгрөгөөр тасарлаа.

Орон нутгийн төсвийн нийт орлого

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөндүнгээр/	Өөрчлөлт	
			Тоо	Хувь
002 ОРОН НУТГИЙН ОРЛОГО	35,668,008,200.00	33,751,577,372.07	(1,916,430,827.93)	94.63
003 ТАТВАРЫН ОРЛОГО	7,826,689,400.00	8,240,320,872.62	413,631,472.62	105.28
004 Орлогын албан татвар	4,660,159,900.00	5,438,335,730.35	778,175,830.35	116.70
016 Хөрөнгийн албан татвар	371,664,900.00	481,986,310.27	110,321,410.27	129.68
021 Бусад татвар, төлбөр, хураамж	2,619,191,200.00	2,316,261,178.04	(302,930,021.96)	88.43
041 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,841,318,800.00	25,511,256,499.45	(2,330,062,300.55)	91.63
042 Нийтлэг татварын бус орлого	1,119,535,900.00	893,431,534.45	(226,104,365.55)	79.80
049 Хөрөнгийн орлого	0	28,056,760.00	28,056,760.00	#DIV/0!
056 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	20,968,897,600.00	19,781,796,745.00	(1,187,100,855.00)	94.3
058 Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	18,075,333,300.00	18,075,333,300.00	-	100.0
059 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн	2,893,564,300.00	1,706,463,445.00	(1,187,100,855.00)	59.0

орлого				

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТАЛААР:

Аймгийн төсвийн нийт зарлага 40288.9 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 28299.2 сая төгрөгийн гарсан гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлсэн.

Нийт төсвийн зарлагын

- ✓ Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамжинд 58,5%
- ✓ Тогтмол зардалд 18,3%
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардалд 9,8%
- ✓ Хөрөнгийн зардалд 13,4% байна.

Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 3631.2 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 18075.3 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүллээ.

Орон нутгийн төсвийн нийт зарлага

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,288,935,300.00	28,299,176,243.11	(11,989,759,056.89)	70.2
Цалинхөлсболоннэмэгдэлурамшил	18,842,127,600.00	14,911,951,195.55	(3,930,176,404.45)	79.1
Ажиллолгогчооснийгмийндаатгалдтөлөхшимтгэл	2,460,743,900.00	1,716,994,830.13	(743,749,069.87)	69.8
Бараа үйлчилгээний бусад зардал	2,684,702,600.00	1,600,428,067.15	(1,084,274,532.85)	59.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,429,905,500.00	985,709,867.52	(444,195,632.48)	68.9
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,059,047,300.00	3,035,179,733.00	(4,023,867,567.00)	43.0

ЖИЧ: Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээлэлийг Аймгийн ЗДТГ-ын № 15 тоот өрөө, www.dornod.gov.mn вэб сайт, 70583034, 70582372 дугаарын утсаар авч болно

Дөрөв. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтэд тогтмол хяналт тавьж, аймгийн Засаг даргын 270 захирамжид виз өгч ажиллаад байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж нийт 13 өргөдөл ирүүлснээс 3 өргөдөл гомдлыг шийдвэрлэн холбогдох хариуг иргэдэд өгч ажилласан. аймгийн Засаг даргад хандан мөнгөн тусламж хүссэн 3 иргэнд 1.500.000 төгрөгийн буцалтгүй тусламжийг олгуулах ажлыг зохион байгуулаад байна.

Аймгийн Цагдаагийн газрын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тасаг болон Баян-Уул, Хөлөнбуйр, Сэргэлэн Чойбалсан сумдын хэсгийн байцаагч нарт автомашин худалдан авахад дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төсвийн 113.0 сая төгрөгөөр Баян-Уул, Хөлөнбуйр, Сэргэлэн, Чойбалсан сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт тус бүр 1 автомашиныг худалдан авах тендерийг Орон нутгийн өмчийн газраас зарласан Тус тендэр сонгон шалгаруулалтад шалгарсан компанитай 5 дугаар сарын 28-ны өдөр гэрээ байгууллаа. Гэрээний дагуу 2020 оны 6 дугаар сард 4 автомашиныг хүлээн авна.

Архивын чиглэлээр:

Аймгийн Архивын тасаг нь Монгол улсын Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх” үндэсний хөтөлбөрийн дөрөвдүгээр үе шат /2017-2020/-нд гүйцэтгэх арга хэмжээний төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1. Албан хэрэг хөтлөлт, хууль тогтоомж, шийдвэрийн талаар:

Архивын тасагт 2020 оны 5 дугаар сарын 31-ний байдлаар ирсэн 7 албан бичгийг авч бүртгэн, гадагш 3 тодорхойлолт, 7 албан бичиг боловсруулж явуулсан байна. 2 хариутай бичгийг хугацаанд нь хүргүүлж ажилласан.

2. Баримт ашиглалтын талаар:

5 дугаар сард 2 байгууллага, 125 иргэнээс лавлагаа мэдээллийн захиалга хүлээн авч 403 хуулбар, 19 тодорхойлолт, 29 иргэнд 203 оны малын А данс гаргаж нийт 2 225 500 төгрөгийн орлого оруулав. Хадгаламжийн сангаас 47 хөмрөгийн 207 хадгаламжийн нэгжийг гаргаж ашиглан бүртгэж буцаан байрлуулав.

2020 ий 5 дугаар сарын 1-ны өдрөөс 31-ий өдөр 50 хэдгэлэлт 15 23 369 хөддүй дүйгүй өдөөдөөд 50 хэдгэлэлт 1 517 360 өдөөдөөд өдөөдөөд 47 хэдгэлэлт 1 454 860 өдөөдөөд өдөөдөөд байна.

Шинээр 1 байгууллагын материалыг хүлээн авч эх хувийг бэлтгэн стандартын дагуу хэвлэж өгөв.

3.Цахим хэлбэрт оруулсан баримтын талаар:

2020 онд цахимжуулах төлөвлөгөөг боловсруулж, сар, улирал, өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөн ажиллаж байна.

- Цахим холболт- 172 хадгаламжийн нэгжийн 9873 хуудас баримт
- Хүний нэр-28 403
- Агуулга-9752
- Байгууллагын нэр-10
- Газар зүйн нэр-11

Мөн хөмрөг 92 буюу Нэгдсэн эмнэлэгийн 1985-1988 оны 5 хадгаламжийн нэгжийн 789 хуудасыг фотошопдож, PTF файл үүсгэн ажиллаа.

4. Зөвлөгөө

Дорнод дээд сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэл төв, Булган сумын Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төвийн ажилтнуудад заавар зөвлөгөө өгөв.

5.Баримтын нөхөн бүрдүүлэлт

5 дугаар сард Хэрлэн сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт “Их базар” ХХК хийж гүйцэтгэсэн Стандарт хэмжил зүйн хэлтсийн барилга, “Дөшийн нуруу” ХХК хийж гүйцэтгэсэн Хэрлэн сумын 12 дугаар сургуулийн спорт заалны барилгын засварын ажил, “Баян луу” ХХК хийж гүйцэтгэсэн 12 дугаар цэцэрлэгийн дээвэр, 14 дүгээр цэцэрлэгийн биеийн тамирын талбайн тохижилт,Баянтүмэн сумын сургуульд тоног төхөөрөмж нийлүүлэх ажил, “Ган Окта эдр” ХХК хийж гүйцэтгэсэн “Шинэ хөгжил” цогцолбор сургуулийн цэвэр ус хангамжийн гадна шугам хоолойн засвар, Хэрлэн сумын 2 дугаар цэцэрлэгийн дулааны узелийн угсралтын ажил, Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн барилгын халаалт болон хэрэглээний халуун усны узелийн засвар, “Нью бест хаус” ХХК хийж гүйцэтгэсэн Боловсрол, соёл урлагын газрын засвар, “Бүжнар” ХХК хийж гүйцэтгэсэн Хэрлэн сумын 5 дугаар сургуулийн хойт талын хашааны хэсэгчилсэн ажил, Баянтүмэн сумын сургуулийн байрыг дотуур байртай хүзүүвчээр холбох ажил зэрэг ажлыг хүлээн авах комиссд орж заавар зөвлөгөө өгч ажиллав.

6.Бусад

Хадгаламжийн сангийн цэвэрлэгээ үйлчилгээг 5 дугаар сарын 7, 14,28-ний өдрүүдэд, чийг дулааны хэмжилтийн бүртгэлийг 5 дугаар сарын 7,13,27-ны өдрүүдэд хөтөлж ажиллаа.

Тав. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Нэг. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар батлагдсан “Бүх нийтээрээ мод тарих үндэсний өдөр”-өөр байгууллагын гадна болон “Чойбалсан” Олон Улсын Нисэх буудлын зам дагууа талбайд тарьсан модны нөхөн тарилт хийж, арчилж услаж, орчны хогийг цэвэрлэв.

Иргэдийг идэвхтэй хөдөлгөөнөөр дархлааг дэмжих уриалга бүхий самбаруудыг хүн олноор цугларах боломжтой газруудад байршуулав.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/288 дугаар захирамж хэрэгжилтийн хангахаар байгууллагын 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй 1 албан хаагчийг 2020 оны 05 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл цалинтай чөлөөг олгож, гэрээс ажиллах нөхцөл боломжоор хангав.

Байууллагын дотоод болон гадаад цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг нийт 4 удаа зохион байгуулав.

Гаднаас ирж байгаа хүмүүсийн бүртгэлийн хөтлөн, байгууллагад нэвтрүүлж байна.

Хэрлэн сумын 11 багийн хүүхдийн талбай, спорт болон чийрэгжүүлэлтийн талбайн хэмжилт болон эвдрлийн тоон судалгаа гаргав.

Байгууллагын үүдний самбар шинэчлэх болон заалны сандлын доорх хогийг цэвэрлэв. Мөн гадна болон дотор ногоон байгууламжийг нэмэгдүүлэв.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газраас зохион байгуулсан “Спорт клубыг магадлан итгэмжлэх” цахим сургалтад оролцов.

**Хоёр. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
Боловсрол, соёл, урлагийн газар**

Салбарын хэмжээнд хийгдсэн хөрөнгө оруулалт:

Улсын төсвийн санхүүжилтээр Хэрлэн сумын 4, 9, 17 дугаар цэцэрлэгт “Хөгжим, техник хэрэгсэл худалдан авах” ажлыг 14,0 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилтээр “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад тоног төхөөрөмж нийлүүлэх” ажлыг 19,1 сая төгрөгөөр “Протек” ХХК нийлүүлсэн.

Багш, суралцагчдыг чадваржуулахад чиглэсэн үйл ажиллагаа:

Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдөд зориулсан Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлага 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн Дорнод аймгийн 19 сургуульд 83 танхимд 10 хичээлээр 667 сурагч хамрагдаж, хичээлийг мэргэжлийн 184 багш удирдаж байна. Хорио цээрийн дэглэмтэй холбоотой сургууль, анги танхимын ариутгал, халдваргүйтгэлийг Эрүүл мэндийн яам, БСШУСЯ-аас өгсөн зөвлөмжийн дагуу сайтар ханган ажиллаж байна.

Математик, Хими, Физик хичээлүүдийн онлайн сорилыг зохион байгуулж, 18 сургуулийн математикийн хичээлээр 18 сургуулийн 49 багш, 443 сурагч, физикийн хичээлээр 8 багш, 176 сурагч, химийн хичээлээр 11 багш 89 сурагч хамрагдсан. “Зайны сургалтын шилдгүүд” уралдааныг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудын багш, сурагч, эцэг эхийн дунд зохион байгуулж, 64 багшийн арга туршлагыг БСШУСЯ, аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим сайт, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газрын <https://dornodedu.mn/> цахим сайтад болон олон нийтийн албан ёсны цахим сулжээгээр нийтлэн, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажлыг хийсэн.

Аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны дунд “Сэтгэх чадвар 2020” онлайн уралдаан анх удаа 5 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж, 14 захирал, 31 сургалтын менежер, 11 нийгмийн ажилтан, 3 мэргэжилтэн, 306 багш нийт 365 хүн хамрагдсан.

Физик, математикийн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг МУИС, МУБИС-ийн математикийн статитикийн сургуулийн багш Ч.Зоригт, Ч.Гантөмөр нартай 25 сургуулийн 75 багш хамрагдав.

Олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа:

Төгсөх ангийн суралцагчдад мэргэжлээ хэрхэн сонгох, ЭЕШ-д бэлтгэхэд зөвлөн туслах, аймгийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн болон багш нарын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, Дорнодын боловсролын салбарын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд цахим хэлбэрээр нээлттэй сурталчлах зорилгоор “Дорнодын боловсрол 2020” онлайн өдөрлөгийг 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан.

Улсын Онцгой комисс, Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр дэлхий нийтээр тархаж буй шинэ короавируст /Covid-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвараас хамгаалах зорилгоор улс даяар өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотой хүүхдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургууль дахь хүүхэд хамгааллын баг, хороо болон багийн нийгмийн ажилтан хамтарсан эргүүл хяналт хийх удирдамж чиглэл өгч, хэрэгжилтийн тайлан мэдээг 7 хоног бүрээр гарган холбогдох газарт тогтмол хүргүүлэн ажиллаж байна. 2020 оны 05 дугаар сарын 01-30-ны хугацаанд ерөнхий боловсролын 24 сургуулийн 1393 багш, ажилтан харьяа багийн 782 объектод эргүүл хяналт хийж, 6977 хүүхэд, 4924 насанд хүрэгчдийн бөөгнөрлийг таслан зогсоосон байна. Эргүүл хяналтын явцад 6689 багш, 7127 эцэг эх, асран хамгаалагчдад Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын халдвараас сэргийлэх зөвлөмж, “Хүүхэд гэрийн аюулгүй байдлыг хангая”, “Хүүхдийг түлэгдэл эрсдлээс хамгаалъя”, “Маск зүүцгээе” зэрэг зөвлөмж, брошур тараан, 5246 хүүхэд, 4844 насанд хүрэгчдэд маск, амны хаалт зүүхийн ач холбогдлыг таниулах зөвлөгөөг өгч ажиллав.

***Гурав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар***

“Өргөдөл, гомдол”-ын шийдвэрлэлтийн мэдээлэл:

Тайлант сард хүүхэд, гэр бүлийн эрх зөрчигдсөн асуудлаар өргөдөл, гомдол, хүсэлт, хүүхдийн тусламжийн 108 утсаар нийт 7 дуудлага, 1 өргөдлийг хүлээн авч, хуулийн дагуу хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж ажилласан бөгөөд шийдвэрлэлт 60 хувьтай байгаа бөгөөд “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө” энэ сард нийт 12 хүүхэд, иргэн давтамжтай зөвлөгөө үйлчилгээ авсан. “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д энэ сард гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 7 насанд хүрэгч, хүүхдийг хүлээн авч, 2-30 хоногийн хугацаатай байршуулж, аюулгүй байдалд хяналт тавин эрүүл мэнд, сэтгэлзүй, хууль эрх зүйн болон холбон зуучлах, хамгааллын үйлчилгээг үзүүлэн харьяа хамтарсан багт шилжүүлэн, үйлчлүүлэгчтэй ажиллах кейс төлөвлөгөө боловсруулан хариу үйлчилгээ үзүүлж байна. Үрчлэлтийн дүгнэлт хийгдэхээр ирүүлсэн 2 өрхийн нөхцөл байдлыг судлан дүгнэлтийг гарган Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Мөн “Анна хоме” асрамж халамжийн төвд хараа хяналт сул 3 хүүхдийг холбон зуучилж, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлөөр ханган ажилласан.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн хурлыг цахимаар зохион байгуулж, хуралд зөвлөлийн гишүүдээс гадна сумдын Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нар хамрагдав.

Хурлаар 06 дугаар сарын 01-ний өдөр мэндэлсэн хүүхдэд Хүүхдийн төлөө зөвлөлийн нэрэмжит гарын бэлгийг жил бүр гардуулах, энэ жилийн Хүүхдийн баярыг гэр бүлдээ тэмдэглэн өнгөрүүлэх, хүүхдийн бөөгнөрлийг үүсгэхгүй байх, баярын өдрүүдээр цахим, олон нийтийн сүлжээгээр хүүхэд, гэр бүлд зориулсан нэвтрүүлэг, контент, зөвлөмжийг дамжуулах, аймаг, сумдын Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүн бүр хүүхдэд зориулсан шинэлэг ажлыг санаачлан хэрэгжүүлэх, хүүхдийн оролцооны байгууллагын санал санаачилгыг дэмжин ажиллах, гэр бүл, хүүхдийн хүчирхийллийг бууруулах чиг үүрэг бүхий хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, зөвлөн туслах “Дэмжих баг” байгуулах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Мөн аймгийн Онцгой комиссийн 2020 оны 37 дугаар хуралдаанаар хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн сургууль, цэцэрлэгийн “Хүүхдийн тоглоомын талбай”-г нээх шийдвэр гаргасан бөгөөд Хүүхдийн зөвлөлийн хурлаар Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт хяналт тавьж ажиллах чиглэлийг өгсөн.

Мөн орон нутгийн “Гэр бүлийн хөгжил, дэвшил хөтөлбөр”-т хамрагдаж буй 231 өрхийн 642 хүүхдэд аймгийн Хүүхдийн төлөө Зөвлөлөөс витаминь багц бүхий гарын бэлгийг олгохоос гадна “Гэр бүлийн боловсрол олгох модуль 2” сургалтыг бэлтгэж, олшруулан гарын авлагаар хүргүүлэв. Мөн “Лантуу хүүгийн богц” хандивын үйл ажиллагааг дэмжин Хэрлэн сумын 4, 6, 7, 9, 11 дүгээр багаас эмзэг өрхийн судалгааг авч, холбон зуучилснаар 120 өрхөд хүнсний дэмжлэг, баярын бэлгийг олгосон.

Олон Улсын Гэр бүлийн өдрийг тохиолдуулан Хэрлэн сумын Ахмадын хороотой хамтран “41-52 жил хамтдаа ханилсан, олон хүүхэд төрүүлж, өсгөсөн, нийгэмдээ тустай хөдөлмөрлөж, төрдөө үнэлэгдсэн Хэрлэн сумын 1, 6, 7, 10 дугаар багийн 4 ахмад гэр бүлийг “Тэнгэрлэг гэр бүл”-ээр шалгаруулан, хүндэтгэл үзүүлсэн. Мөн “Буянтай ээж”, “Дархан бэр”, “Хатан бэр”-ээр 21 ээжийг тодруулан өргөмжилж, хүндэтгэл үзүүлж, “Ээжтэйгээ дуулах хамгийн жаргалтай” үйл ажиллагааг зохион байгуулж, ахмад залуу үеийн залгамж холбоо, хамтын ажиллагааг өргөжүүлэн ажилласан.

“Хүүхэд хамгаалагч” төслийн хүрээнд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран “COVID 19” цар тахлын халдвар, тархалтаас урьдчилан сэргийлж, улсын хэмжээнд хөл хорио тогтоосонтой холбоотойгоор хүүхдийн тоглоомын талбай, гудамж талбайд насанд хүрээгүй хүүхдүүд тоглох, бүлэг бөөгнөрөл үүсэхгүй байх, насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Эргүүл шалгалт хүүхэд” арга хэмжээг эхлүүлээд байна. Энэ хүрээнд Хэрлэн сумын 11 багийн хэсгийн ахлагч, Хүүхэд хамгаалагч нийт 24 хүн хамруулан эргүүл хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын “Онцгой нөхцөл байдлын үед эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд дэмжлэг тусалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах тухай” 2020 оны А/101 дугаар тушаалыг хэрэгжүүлэх хүрээнд Дорнод аймагт хүүхдийн асрамж, халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Анна хоме” асрамж, халамжийн төвд 1,5 сая төгрөгийн хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэхээс гадна төв байрлаж буй хүүхдүүдийн дархлааг дэмжих витаминь багцыг олгосон.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банктэй хамтран ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн сонгон шалгаруулалтад “Орон нутагт Гэр бүл-хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах нь” сэдэвт төслийг боловсруулан хүргүүлсэн.

Залуучуудын хөгжил оролцооны чиглэлээр:

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучууд хөгжлийн төвөөс “Амьдрах ухааны чадвар олгох 12 модуль сургалт”-ыг цувралаар өсвөр үе, залуучууддаа тогтмол зохион байгуулж байна. Тайлант сард аж ахуй үйлчилгээнд ажиллаж, хорих ял эдэлж байгаа, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдүүд, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Цагдаагийн газрын эрүүлжүүлэх саатуулах байрны баривчлах байранд хүмүүжиж байгаа нийт 70 иргэд, хүүхдэд “Жендэрийн тухай ойлголт”, “Харилцаа хандлага”, “Өөртөө итгэх итгэл”, “Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах”, “Стрессыг зохицуулах нь”, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, “Холбоо тогтоох чадвар” сэдвүүдээр сургалтыг зохион байгуулав.

Бусдын тусалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 5 залуучуудад “Хүрч очих үйлчилгээ”-г үзүүлж, амьдрах ухааны чадвар олгох, хувь хүний хөгжлийг дэмжих цуврал сургалтыг хүргэн ажилласан.

Дөрөв. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын хэлтэс

Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтийн талаар:

Нийгмийн даатгалын санд 2020 оны 05 дугаар сард 3431814,7 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1812323,2 мянган төгрөг төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 52,8 хувиар биелүүлсэн байна. 2020 оны 05 дугаар сарын мэдээгээр нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

Нийгмийг даатгалыг сангийн орлого /мянган төгрөг/

д/д	Төрөл	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Тэтгэврийн даатгалын санд	706803.5	1728105.92	57,1
2	Тэтгэмжийн даатгалын санд	70102.8	190601.33	66,7
3	ҮОМШӨ-ний даатгалын санд	53277.8	192078.65	75,6
4	Ажилгүйдлийн даатгалын санд	12053.8	41336.86	80,8
5	ЭМД-ын сан	1020884,4	525162.19	36,7
	Нийт	3431814,7	1812323,24	52,8

Орлогын төлөвлөгөө биелээгүй шалтгаан нь Шинэ төрлийн корона вирусын цар тахалтай холбоотойгоор аж ахуйн нэгж байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэхтэй холбоотой Улсын Их Хурлын 2020 оны 04 дүгээр сарын 9-ний өдрийн нэгдсэн чуулганаар баталсан Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх Засгийн газрын 2020 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг хэрэгжүүлэн ажилласантай холбоотой байна.

2020 оны 05 дугаар сард нийт 597 ажил олгогч байгууллагын 4755 даатгуулагчийн 743508,0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлээс (ЭМД-ын шимтгэлээс бусад) чөлөөлсөн.

Түүнчлэн 2415 сайн дурын даатгуулагчдын 136930,5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлээс тус тус чөлөөлсөн байна.

2. Тэтгэвэр тогтоолт, олголтын талаар:

Аймгийн хэмжээнд 2020 оны 05 дугаар сард шинээр нийт 149 иргэнд тэтгэвэр тогтоосон. Үүнээс:

- Өндөр насны тэтгэвэр 122, (малчин 40, хувь тэнцсэн 10, хүүхдээр 25, хүнд нөхцлөөр 2, цэргийн алба хаасны тэтгэвэр 6, хэвийн өндөр настан 39)
- Тахир дутуугийн тэтгэвэр 26,
- Тэжээгч алдсаны тэтгэвэр 1 тус тус тогтоов.

Түүнчлэн 2020 оны 05 дугаар сард нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас нийтдээ:

- Өндөр настан 8837,
- Тахир дутуу 2773,
- Тэжээгчээ алдсан 608,

- Цэргийн тэтгэвэр-594 нийт 12812 тэтгэвэр авагчдад нийт 4896266,3 мянган төгрөгийн тэтгэвэр олголоо.

3. Тэтгэмж олголтын талаар:

Тэтгэмжийн даатгалын сангаас:

- Хөдөлмөрийн чадвар түр алдсны тэтгэмж 176,
- Жирэмсэн амаржсны тэтгэмж 115,
- Оршуулгын тэтгэмж 32 даатгуулагчид, нийт 187604,4 мянган төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон.

4. Ажилгүйдлийн тэтгэмж олголтын талаар:

Аймгийн хэмжээнд 2020 оны 5 дугаар сард нийт 86 даатгуулагчдад 47,2 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг бодож олгов. Энэ нь өмнөх сартай харьцуулахад 18 даатгуулагчийн 6,0 сая төгрөгөөр ажилгүйдлийн даатгалын зардал буурсан үзүүлэлттэй байна.

5. Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардал:

Уг сангаас нийт 91 тэтгэвэр авагчдад 140555,4 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон байна. Рашаан сувиллын зардал олгоогүй.

6. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагын чиглэлээр:

2020 оны 05 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 647072.2 мянган төгрөг байна. Нийт шимтгэлийн авлагын 82,1 хувь буюу 530891.9 мянган төгрөгийг аж ахуйн нэгж байгууллагуудын авлага, 17,9 хувь буюу 116180.3 мянган төгрөгийг төсөвт байгууллагууд эзэлж байна. Нийт авлагын 39,8 хувийг 121 ба түүнээс дээш хоногтой хуримтлагдсан авлагын дүн эзэлж байна.

7. Ажилгүйдлийн даатгалын сангаас ажил олгогчдод дэмжлэг үзүүлэх талаар:

Цар тахлын улмаас орлого нь 50 буюу түүнээс дээш хувиар буурсан ажил олгогч байгууллагад ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбоотойгоор ажилгүйдлийн даатгалын сангаас 56 ажил олгогч байгууллагын 456 даатгуулагчид 91200,0 мянга төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.

8. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаа:

Шинэ коронавируст халвар (COVID-19) гарсантай холбогдуулан иргэдийг олноор цуглуулахгүй байх шийдвэр гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн

магадлах комисс цахимаар 4 удаа хуралдаж, 281 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөр зохицуулалтын асуудлыг шийдвэрлэснээс 40 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалсан.

190 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгасан, 51 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоосон байна.

Цуцлагдсан 40 иргэний 25 нь өндөр насны тэтгэвэр тогтоолсон, 9 нь заалтын хугацаа дууссан, 6 нь эмчлэн эрүүлжсэн иргэд байна.

9. Дотоод ажил, сургалт сурталчилгаа, олон нийттэй харилцах чиглэлээр:

2020 оны 05 дугаар сард үдийн цайны цагаар 170 иргэнд, 1365 иргэнд угтах үйлчилгээг үзүүлэн ажиллав. Түүнчлэн Нээлттэй утас 70585955 дугаарт хандсан 92 иргэн даатгуулагчид зөвлөгөө өгч, мэдээлэл өгсөн.

Архиваас 64 даатгуулагчид лавлагаа олгохоос гадна бусад 8 аймаг, дүүргээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 17 иргэнд лавлагаа олгож, тэдний нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг баталгаажуулан ажилласан.

Түүнчлэн Олон Улсын Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2020 оны 05 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд Монголын бүтээмжийн төвөөс зохион байгуулсан онлайн сургалтад 3 байцаагч, ажилтныг хамруулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж эхлээд байна.

Тав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээллээр хангах үйлчилгээ:

Ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй, ажилгүйдэлд өртөж болзошгүй, их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль төгссөн 151 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгсөнөөс хөдөлмөрт бэлтгэх зөвлөгөөг 26 иргэн, хөдөлмөр эрхлэлтийн талаар 71 иргэн, мэргэжлийн талаар 54 иргэнд зөвлөгөө өгөөд байна. Зөвлөгөө мэдээлэлд хамрагдсан иргэдийг насны ангиллаар авч үзвэл 15-24 насны 29 иргэн, 25-34 насны 46 иргэн, 35-44 насны 49 иргэн, 45-54 насны 25 иргэн, 60-аас дээш насны 2 иргэн тус тус хамрагдсан байна.

Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэний мэдээ:

Нийт 64 аж ахуй нэгж, байгууллага, иргэнээс 587 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирүүлсний дагуу “Дорнод ажлын байр” хуудас болон хэвлэмэл хуудсаар иргэдэд санал болгож, 304 иргэнийг ажлын байранд зуучлаад байна.

Ажилд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл:

Бүртгэлтэй ажил хайгч, ажилгүй иргэний хөдөлгөөний мэдээ:

Нийт 1644 ажил хайгч иргэн, үүнээс 716 эмэгтэй бүртгэлтэй байна. Үүнээс 51 хувийг бүрэн дунд боловсролтой иргэд, 17 хувийг тусгай, техникийн боловсролтой иргэд, 16 хувийг дээд боловсролтой иргэд, 7 хувийг суурь боловсролтой иргэд тус тус эзэлж байна.

Шинэ ажлын байр:

Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй 1644 иргэнээс түр болон улирлын ажлын байранд 70 иргэн, байнгын шинэ ажлын байранд 135 иргэн тус тус зуучлагдсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр:

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөр Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2020 оны 01 дүгээр тогтоолоор баталсан Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр, Ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлд танилцуулан 2020 онд хэрэгжих үйл ажиллагааны салбар, чиглэлийг батлуулсан.

Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн танилцуулга болон мэдээллийг бэлтгэж, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөс 4 дүгээр сарын 17-ны хүртэл төсөл хүлээн авах, ил тод, нээлттэй зохион байгуулах чиглэлээр аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын цахим хуудсаар болон ТВ-6, Jaran.mn, fm86.1, Мижи телевизүүдтэй хамтран ажиллаж иргэдэд хүртээмжтэй байдлаар шторк, хөтөлбөрийн танилцуулга мэдээллийг хүргэж, 4 сарын 25-аас нөхцөл байдлын үнэлгээ хийж ажиллаа.

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр:

Мэргэжлийн болон давтан сургалт:

Дорнод аймгийн Үсчин, гоо засалчдын холбоодын захиалгаар нийслэлийн “Londa ps” сургалтын төвтэй хамтран мэргэжлийн давтан сургалтыг 50 иргэнд зохион байгуулсан.

Үйлдвэр дээрхи сургалт:

Төмөр замын бетон дэр үйлдвэрлэлийн “Ган хийц” ХХК-тай хамтран бетон арматурчин мэргэжлээр ажилгүй 10 иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй 5 иргэний нийт 15 иргэнийг үйлдвэрлэлийн нөхцөлд гэрээ байгуулан ажиллаж байна. Сургалтын онол, дадлагыг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулж байна.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр:

Ахмад зөвлөх үйлчилгээ:

Ахмад настны хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, мэдээллийн сан үүсгэх, тэдний мэдлэг ажлын туршлагыг өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, өсвөр хойч, залуу үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр ажиллуулж, орлогын эх үүсвэрт дэмжлэг үзүүлэх зорилгоор 65 ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч, 40 ахмад мэргэжилтэнтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд “Гарааны бизнесийг дэмжих Start up” төвийг шинээр байгуулахад шаардлагатай тохижилт, тоног төхөөрөмжийн төсвийг 2020 оны төсөвт тусгуулсан бөгөөд уг арга хэмжээг орон нутгийн болон төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах журмын дагуу тендер зарлагдаж, нээлттэй тендерт 4 аж ахуй нэгж үнийн саналаа ирүүлснээс “Ган тэлмэн” ХХК шалгарч 120,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлснийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг хүлээн авсан.

Тус хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэдийн хүсэлтийг хүлээн авч “Дорнод талын хөгжлийн хөтөч” сургалтын байгууллагатай хамтран аж ахуй эрхлэлт, бизнес хөгжлийн сургалтад 40 залуучуудыг хамруулсан.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 1844 иргэн хамрагдаж, 493,4 сая төгрөг, асаргааны тэтгэмжид 1342 иргэнд 119,2 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжид 1234 иргэнд 137,0 сая төгрөг, эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмжид 4908 иргэнд 230,7 сая төгрөг, ахмад настанд олгох тусламж, хөнгөлөлтөд 205 иргэнд 48,8 сая төгрөг, алдар цолтой ахмад настны нэмэгдэл, хөнгөлөлтийг 28 ахмад настанд 4,3 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тусламж, хөнгөлөлтийг 270 иргэнд 19,6 сая төгрөгийг тус тус олгов.

Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ, хүүхдийн мөнгөний талаар:

Тайлант сард хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 14 сумын 2322 өрхийн 6898 том хүн, 6046 хүүхдэд нийт 12944 хүнд хүргэж, 317,472.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд 69 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч бүртгэн ажиллав. Үүнээс өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдахыг хүссэн 58 өргөдөл, амьжиргааны түвшингийн тодорхойлолт авахыг хүссэн 11 өргөдөл байна.

Халдварт короновирус /КОВИД-19/ өвчний дэгдэлттэй холбогдуулан улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэний улмаас Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны өрхөөр зочлох үйл явцыг бэлэн байдлын үед хориглосон. Шийдвэрлэгдээгүй байгаа өрхийн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн насанд хүрсэн гишүүнтэй эргэн холбогдон өрх дэх 0-18 насны хүүхдийн хүүхдийн төрсний гэрчилгээг хуулбарлан авч мэдээллийн сангийн “Хүүхдийн мөнгө” цэсэнд бүртгэн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгож байна.

Амьжиргааны түвшний 409,679 босго шугамаас доогуурт багтсан 11 иргэнд тодорхойлолт олгож, шинээр төрсөн 193 хүүхдийн мэдээллийг төрсний гэрчилгээний хуулбарыг үндэслэн өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэв.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний чиглэлээр:

Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан холбогдох газруудад хүргүүлээд байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол нийгмийн хамгааллын салбар комиссын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс” энэ сард 1 удаа хуралдаж, 9 хүүхдийн асуудлыг хэлэлцэн 5 хүүхдийн байнгын асаргааг шинээр тогтоож, 1 хүүхдийн байнгын асаргааг цуцлан, 2 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй болохыг тодорхойлж, 1 хүүхдийн байнгын асаргааг сунгав. Мөн 6 хүүхдийг эрүүл мэндийн үйлчилгээнд, 8 хүүхдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд холбон зуучлаад байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих аймгийн салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн Ерөнхий газарт хүргүүлсэн.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ:

Зөвлөгөө өгөх үйлчилгээ:

“Аминчлахуй” Төрийн бус байгууллагаас согтуурах, мансуурах донтой иргэдэд ганцаарчилсан амьдралын итгэл үнэмшил олгох, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, архины хор хөнөөлийн талаар насанд хүрэгчийн сэтгэл зүйн зөвлөгөө, гэр бүлийн сэтгэл зүйн зөвлөгөө гэх зэрэг сургалтын хөтөлбөрийн дагуу зөвлөгөө өгөх үйлчилгээг зохион байгуулсан.

Зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдсан зорилтот бүлгийн иргэдийн нийгмийн идэвхи сайжирч, өөрийгөө илэрхийлэх чадвар нэмэгдсэн. Архи болон тамхины хор хөнөөлийн тухай шинжлэх ухааны үндэслэлтэй илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй болж, архи, тамхинаас татгалзах эрүүл амьдралын хэв маягт хэвшүүлэх, бусдыг уриалан дуудах дадал эзэмшиж байна. Тайлант хугацаанд архины хамааралтай 15 иргэн үйлчилгээнд хамрагдаж 1,6 сая төгрөг зарцуулсан.

Бүлгийн төсөл:

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зорилгоор 7 бүлгийн төслийн явцтай танилцаж, нөхцөл байдлыг үнэлж дүгнэн 7 бүлгийн төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлж 10,0 сая төгрөг зарцуулсан.

Бүлгийн төслийг үйл ажиллагааны чиглэлээр харуулбал:

- Ногоо, жимс жимсгэнэ 2 бүлэг 2,5 сая төгрөг,
- Гахайны аж ахуй 1 бүлэгт 1,5 сая төгрөг,
- Тахианы аж ахуй 1 бүлэгт 1,5 сая төгрөг,
- Үйлчилгээ /бусад/ 3 бүлэгт 4,5 сая төгрөг тус тус олгосон.

Ахмадын санхүүгийн дэмжлэгт төсөлд ажлын хэсгийн бүрэлдэхүүн нөхцөл байдлын үнэлгээ хийсэн.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд Ахмадын эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг авахаар хүсэлт гаргасан 30 иргэний үйл ажиллагаанд нөхцөл байдлын үнэлгээ хийж байна. Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг нь иргэний үйл ажиллагаа явуулж буй ажлын байртай нэг бүрчлэн танилцан дүгнэлт гаргаж ажилласан.

Зорилтот бүлгийн иргэдэд шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх “багц” хүргэх ажлыг зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас санаачлан зорилтот бүлгийн өрхийн гишүүдэд чиглэсэн шинэ коронавирус өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг Хэрлэн сумын 11 багийн Ажлын албатай хамтран 2020 оны 04 дүгээр сарын 6-8-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Тус ажлын хүрээнд “Өрхийн мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэлтэй амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой Хэрлэн сумын 11 багийн 100 өрхийн 4-18 насны 300 хүүхэд, 19-81 насны 200 иргэн буюу нийт 500 иргэнд халдвараас урьдчилан сэргийлэх, олон удаа хэрэглэх амны хаалт, орчны ариун цэвэр, аюулгүй байдлыг хангах, гар угаах, хоол, хүнсний зохистой хэрэглээний зөвлөмж, гарын авлага, хүүхэд, ахмад настны дархлааг дэмжих чацарганаас бүрдсэн “багц”-ыг хүргэсэн.

Мөн аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Боловсрол, соёл урлагийн газрын удирдлагууд өрхөөр зочлон шинэ коронавирусийн эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, зайны сургалтын чанар, үр дүн хэрэгжилтийн явцтай танилцсан бөгөөд иргэд мэдээ, мэдээлэл сайн байгаа ч гэрийн нөхцөлд урьдчилан сэргийлэх шат дараатай арга хэмжээ аваагүй, хүүхдийн амны хаалт, давс, содын уусмалын хангалт дутмаг, 00-ын ариун цэвэр, гараа зөв угаах дадал хангалтгүй байсан.

Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу Хэрлэн сумын 11 багийн зорилтот бүлгийн 1742 өрхийн 9665 иргэнд “Маскаа зүүцгээе” аяны хүрээнд амны хаалтыг өгч, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулсан.

Зургаа. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар

COVID-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

“Ковид 19 халдварт цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” сэдэвт дадлага сургуулилтыг 2020 оны 05 дугаар сарын 6-8-ны өдрүүдэд зохион байгуулав.

“Халдварын сэргийлэлт хяналт”, “Байгууллагуудад халдваргүйжүүлэлт хийх заавар” сэдвүүдээр сургалт зохион байгуулж, халдвараас хамгаалах хувцасыг өмсөж тайлах дарааллын сургуулилт хийсэн.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/226 дугаар захирамж, “Ковид 19 халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай” аймгийн Онцгой комиссын 32 дугаар хурлын үүрэг даалгавар, Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 1/423 дугаар албан тоотын хэрэгжилтийг хангах зорилгоор Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд 2020 оны 05 дугаар сарын 08-09-ний өдөр нийт 86 супермаркет, дэлгүүр, гоо сайхан, үсчин, аж ахуй нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө, чиглэл өгч ажиллав.

“Дархлаажуулалтын үндэсний өдөр”

“Дархлаажуулалтын дэлхийн 7 хоног, дархлаажуулалтын үндэсний өдрүүд”-ийг тэмдэглэн өнгөрүүлэхээр цахим сурталчилгааны ажлыг зохион байгуулж, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар, нийгмийн эрүүл мэндийн зөвлөгөө өгөх төв, өрх сумын эрүүл мэндийн төвүүдийн цахим хаяг, “Дорнод дархлаажуулалт”, “Дорнодын ээжүүд”, “Дорнодын ажил хэрэгч бүсгүйчүүд” зэрэг цахим бүлгэмүүдэд дархлаажуулалттай холбоотой 15 төрлийн зурагт хуудас инфографик, шторк байршуулж, 4256 иргэн үзэж, давхардсан тоогоор 524 иргэн бусдад хуваалцан, 2430 иргэнд таалагдсан байна. Мөн өрх, сумын эрүүл мэндийн байгууллагын хүлээлгийн танхимын дэлгэцээр Дархлаажуулалтын талаар 2 төрлийн видео бичлэг, шторк зөвлөмжийг нэвтрүүлж, 435 иргэнд сурталчилсан. Орон нутгийн “Дорнод” телевизийн мэдээллийн хөтөлбөрт Дархлаажуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн оролцож, дархлаажуулалтын талаар зөвлөмж, мэдээллийг өгсөн. Товлолын дархлаажуулалтаас хоцорсон 6 хүүхдийг нөхөн дархлаажуулалтанд хамруулсан.

Хачигт халдвараас сэргийлэх вакцин:

Хачигт халдвараас сэргийлэх дархлаажуулалтын давтан тунг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Онцгой байдлын газар, Мал эмнэлэгийн газрын албан хаагч, голомтот нутгийн иргэд зэрэг нийт 994 албан хаагч, В гепатит вирусын вакцины 1 дүгээр тунг зорилтот бүлгийн 31-40 насны 490 эмэгтэйчүүдийг тус тус хамруулсан.

“Согтуу жолоочтой хамтдаа тэмцье 2020” аян:

Аймгийн Засаг даргын 2020 оны А/192 дугаар захирамжаар эхлүүлсэн “Согтуу жолоочтой хамтдаа тэмцье 2020” нэгдсэн арга хэмжээнд аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газрын хамт олон нэгдэж, Баянтүмэн сумын гүүрний постонд хот хооронд зорчиж буй тээврийн хэрэгсэл болон Үйлчилгээний төвийн таксины зогсоолд зогсч буй жолооч нарт “Согтуу жолоочтэй тэмцье” аяныг сурталчилан 17 төрлийн лоозон болон 4 төрлийн 110 ширхэг гарын авлага бэлтгэн нэг өдрийг сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулав.

“Эрүүл оюутан”

“Эрүүл оюутан” төсөл хэрэгжүүлэх ажлын хүрээнд 4 хувийн хэвшлийн шүдний эмнэлэгтэй хамтран амны хөндийн өвчлөлтэй 200 оюутныг эмчилгээнд хамруулахаас 124 оюутан буюу 62 хувийг хамруулаад байна. Эрүүлжүүлэлт 82,9 хувьтай.

Өндөр тунт А аминдэм, олон найрлагат бичил тэжээл:

Жил бүрийн 5 дугаар сард уулгадаг өндөр тунт А аминдэмийг аймгийн хэмжээнд нийт 06-59 сартай 8239 хүүхдэд уулгахаар сум, өрхийн эрүүл мэндийн төвд хуваарилсан. Бага насны хүүхдийг хоол тэжээлийн дутлаас сэргийлэх зорилгоор 15 төрлийн аминдэм, эрдэстэй олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг 6-23 сартай нийт 652 хүүхэд ууж байна. Жирэмсэн, хөхүүл эхийн олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл нэг эхэд 3 сар уух /1 савлагаатай/ 569 ширхэг хүлээн авч анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хуваарилан хүргүүлээд байна.

“Цэрэг татлага 2020”

Аймгийн хэмжээнд 2020 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагыг 04 дүгээр сарын 30-аас 05 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд зохион байгуулсан ба тус үзлэгт Хэрлэн сумаас 537, Баянтүмэн сум 23, Булган сум 43, Дашбалбар сум 2, Сэргэлэн сум 29, Чойбалсан сумаас 51 нийт 685 залуучууд хамрагдсан. Үүнээс эрүүл мэндээр тэнцсэн 196 залуучууд буюу 28,6 хувь, эрүүл мэндээр тэнцээгүй залуучууд 489 буюу 71,4 хувийг эзэлсэн байна. Эрүүл мэндээр тэнцээгүй өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанд мэс заслын шалтгаант эмгэгээр 156 залуучууд буюу 32,0 хувь, дотрын шалтгаант эмгэгээр 114 буюу 23,0 хувь, чих хамар хоолойн шалтгаант эмгэгээр 68 буюу 14,0 хувь, нүдний шалтгаант эмгэгээр 47 буюу 9,6 хувь, жин өндрийн харьцааны алдагдал 26 буюу 5,3 хувийг тус тус эзэлж байна.

“Сувилагч эх баригчийн жил”

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас 2020 оныг “Сувилагч эх баригчийн жил” болгон зарласантай холбогдуулан Дэлхийн Эрүүл мэндийн өдөр, Олон Улсын сувилагчийн өдрийг “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад сувилагч, эх баригчийн үүрэг” уриан дор нэгжүүдэд зохион байгуулсан.

“2020 оны сувилагч, эх баригчийн жил”-ийн хүрээнд сувилагч, эх баригчдын хүний нөөцийг нэмэгдүүлэх, тэдний жлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажиллах орчин, нөхцлийг сайжруулах, нийгмийн асуудлыг төр, хувийн хэвшлийн бүх шатны байгууллагын оролцоотой хамтарч шийдвэрлэж ажиллах шаардлагатай байгаа бөгөөд энэ хүрээнд сувилахуйн, эх барихуйн тусламж, үйлчилгээний чиглэлээр 2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан “Ээлжийн сувилагч, эх баригчийн эрүүл аюулгүй хоол” аяныг 2020 оны 04 дүгээр сарын 07-ноос 28-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж, тус аянд 14 эрүүл мэндийн байгууллага оролцсон.

Аяны хүрээнд 14 эрүүл мэндийн байгууллагын 208 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан ба биеийн жингийн индексийн үзүүлэлтээр туранхай (<18.5 м/кг²) 4 (1,9%), хэвийн (18.5-24.9 м/кг²) 84 (40,3%), биеийн жингийн илүүдэлтэй (25-29.9 м/кг²) 82 (39.4%), таргалалттай (30 < м/кг²) 34 (16.3%) байна. Биеийн жингийн илүүдэл, таргалалттай ээлжийн сувилагч, эх баригч нарыг эзлэх хувь 55,7% байна. Дээрх эрүүл мэндийн байгууллагууд нь ээжлжийн сувилагч, эх баригч нарт өдрийн хоолны цэс гаргаж, 1-3 удаагийн давтамжтайгаар хоолоор үйлчилж ажилласан. Цаашид тус ажлыг хэвшүүлэн ажиллана.

Зорилтот жилийн хүрээнд урьдчилан сэргийлэх багц үзлэгт хамрагдах сувилагч, тусгай мэргэжилтний судалгаа, үзлэг зохион байгуулах удирдамжийг боловсруулан танилцуулсан. Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн графикийн дагуу сувилагч, тусгай мэргэжилтнүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.

Зургаа. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын чиглэлээр:

Шинэ коронавирус /COVID 19/ халдвараас урьдчилан зорилгоор хөдөө аж ахуйн салбарын цаг үеийн мэдээ, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний сумдын нөөц, аймгийн төвийн хүнсний худалдааны төвүүдийн нөөц, үнийн мэдээг 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдрийг дуустал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд shuurhaishtab@mafo.gov.mn хаяг болон 92109109 дугаарын утсанд, аймгийн онцгой комисс өдөр бүр 16:00-18:00 цагийн хооронд dornod.shuurhai.shtab@mail.com хаягаар хүргүүлэн ажиллаж байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйл, Улсын онцгой комиссын 2020 оны 6 дугаар тогтоолыг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 3 дугаар сарын 11-ний өдрийн А/08 тоот тушаалын дагуу Шуурхай жижүүр ажиллаж, 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдрийг дуустал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны шуурхай штаб, Дорнод аймгийн шуурхай штабд цаг үе, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ, аймаг болон сумдын хүнсний худалдааны төвүүдийн нөөцийн судалгааны мэдээг хүргүүлж байна.

Байгууллагын цахим сайт(hhaag.dd.gov.mn), болон олон нийтийн сүлжээ Дорнод аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар нэртэй Page хуудсанд шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаарх амны хаалт зүүх аргачлал, гар ариутгах, олон хүнтэй газраар явахгүй байх зэрэг коронавирусээс урьдчилан сэргийлэх зурагт хуудас, мэдээ мэдээлэл, зөвлөмжийг иргэд олон нийтэд өдөр тутам шуурхай түгээж ажиллаж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын гамшгаас хамгаалах алба, тусгай зориулалтын анги 3, суудлын 1 техник хэрэгсэл бэлэн байдалд байна.

МАЛ АЖ АХУЙ ЧИГЛЭЛЭЭР:

Мал төллөлт: 2019 оны жилийн эцсийн мал тооллогоор 2,629,622 толгой мал тоологдсоны 1,190,051 толгой хээлтэгч буюу нийт малын 45,2 хувийг эзэлж байна.

Үүнд: Ингэ 2320 толгой буюу 0,1 хувь, гүү 95877 толгой буюу 8 хувь, үнээ 107052 толгой буюу 8,9 хувь, эм хонь 616170 толгой буюу 51,7 хувь, эм ямаа 368632 толгой буюу 30,9 хувийг тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 1.190.051 хээлтэгч малаас 1.029.535 толгой төл мал хүлээж авах төлөвлөгөөтэйгээс 2020 оны 05 дугаар сарын 28-ний байдлаар 887390 толгой хээлтэгч мал төллөж, 890495 толгой төл мал хүлээн авч мал төллөлт **86.2** хувьтай байна.

Төл бойжилт **99.3** хувьтай байна.

Төл малын хорогдол нийт төлийн 0,6 хувь буюу 5743 толгой байна.

Мал төлөлтийн мэдээ

№	Төрөл	Төллөсөн хээлтэгч	Төрөл	Гарсан төл	Бойжиж буй төл мал	Төл малын хорогдол
1	Ингэ	929	Ботго	929	919	10
2	Гүү	43978	Унага	43978	43861	117
3	Үнээ	59466	Тугал	59466	59170	296
4	Эм хонь	495863	Хурга	497200	494713	2478
5	Эм ямаа	287154	Ишиг	288922	286089	2833
Бүгд		887390	Бүгд	890495	884752	5743

Том малын зүй бус хорогдол: Аймгийн хэмжээнд нийт 4803 толгой мал буюу нийт малын 0.1 хувийг эзэлж байна.

№	Төрөл	Зүй бус хорогдол	Өвчнөөр хорогдсон мал	Төрөл	Хорогдсон хээлтүүлэгч
1	Тэмээ	-	-	Буур	-
2	Адуу	148	1	Азарга	-
3	Үхэр	496	5	Бух	-
4	Хонь	1742	6	Хуц	21
5	Ямаа	2417	5	Ухна	23
Бүгд		4036	17	Бүгд	44

Дашбалбар суманд бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил, үйлчилгээний нэгжид төвлөрүүлэх чиглэлээр буриад омгийн хурган хуц сонгож ажилласан тухай: Малын генетик нөөцийн тухай хууль, “Монгол мал” үндэсний хөтөлбөр, “Бог малын хээлтүүлэгчийг үржлийн үйчилгээний нэгжид шилжүүлэх үлгэрчилсэн журам”, Дашбалбар сумын Засаг даргын А/71 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил, үйлчилгээний нэгжид төвлөрүүлэх чиглэлээр ОНХС-гийн хөрөнгөөр Харзат багийн 11 малчин өрхийн Буриад омгийн хонин сүргээс 76 толгой хурган хуц сонгож ажиллаа. Цаашид Буриад омгийн хурган хуцыг 100 толгойг сонгож, Чух багт бог малын хээлтүүлэгчийн суурь нэгийг шинээр

Энэхүү арга хэмжээг зохион байгуулснаараа бог малын хээлтүүлэгчийг технологийн дагуу арчилан маллаж, мал эмнэлгийн урьчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулах, амьдрах чадвар дээшилж, 100 эхээс бойжуулах төлийн тоог нэмэгдүүлэх, малчид хээлтүүлэгчдийг мэргэжлийн хоршоо, ажил, үйлчилгээний нэгжээс гэрээ, түрээсээр ашигладаг үйлчилгээний зохистой хэлбэрийг бий болгох, төрлийн үржүүлэгт орж цус ойртох, бие давжаарах асуудалгүй болох, малын чанар сайжирч малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсч, малчдын орлогыг нэмэгдүүлэх юм.

Үржлийн малд үзлэг, ангилалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулсан тухай :

Малын генетик нөөцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.4.5, Дорнод аймгийн 2016-2020 оны хэтийн зорилтын 9.4, Дорнод аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.7, аймгийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3.4.2 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А-112 дугаар тушаал, аймгийн Засаг даргын А/224, А/42, Дашбалбар сумын Засаг даргын А/79, А78 дугаар захирамж, Хөлөнбуйр сумын Засаг даргын А/84 дугаар захирамж, Халхгол сумын Засаг даргын А/61 дугаар захирамж шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Улсын болон орон нутгийн төсвийн 31,5 сая төгрөгийн хөрөнгөөр Үржлийн малд үзлэг, ангилалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх арга хэмжээнд Дашбалбар сумын Харзат багийн 14 малчин өрхийн Буриад омгийн 8666 толгой хонь, Хөлөнбуйр сумын 2 багийн 11 малчин өрхийн Барга үүлдрийн 4000 толгой хонь, Халхгол сумын 3 багийн 32 малчин өрхийн Дорнод Монголын улаан үүлдрийн 5000 толгой үхэр аймгийн хэмжээнд нийт 3 сумын 57 малчин өрхийн 17666 толгой малд үзлэг, ангилалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлснээс Дашбалбар сумын Буриад омгийн 1120 толгой хонь, Хөлөнбуйр сумын Барга үүлдрийн 523 толгой хонь, Халхгол сумын Дорнод Монголын улаан үүлдрийн 500 толгой үхэр, нийт 2143 толгой ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Мөн үржлийн малд үзлэг, ангилалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг малчин өрх бүртэй гэрээ байгуулан, батламж гардуулсан.

Дээрх арга хэмжээг "Үет цагааны гол" ХХК, "Баянмөнх галуут" ХХК-ууд гүйцэтгэсэн.

Бэлчээрийн үлийн цагаан оготной тэмцэх ажлын хяналт тавьж ажилласан тухай: Үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А/89 дугаар тушаал, Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2020 оны А/219 дугаар захирамжийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын удирдамжаар баталсан ажлын хэсэг Баянтүмэн, Булган, Матад, Хөлөнбуйр, Халхгол, Цагаан-Овоо, Баян-Уул сумдад 2020 оны 05 дугаар сарын 12-нөөс 22-ны хооронд байгаль орчинд халгүй энгийн механик аргаар үлийн цагаан оготно устгах ажлын явцад хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа. Сумдын ажлын явц дунджаар 65,0 хувьтай хийгдэж байна.

Халхгол сум, Буйр нууранд ажилласан тухай: Халхгол сум Буйр нуурын зүүн эрэг дагуух элсний нүүдлийн нөхцөл байдлыг газар дээр нь үзэж дүн шинжилгээ хийх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2020 оны А/284 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь 2020 оны 5 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд Халхгол сум, Буйр нууранд ажиллалаа.

Судалгааны ажлын дүгнэлт

1. Бэлчээрийн ургамлын судалгааны ажлын дүнгээс авч үзэхэд тухайн бэлчээрийн 3 цэг нь элсэрхэг хөрстэй, хөрсний нүүдэл, элсний хуримтлал илрээгүй байна.

2. Тухайн элсний хуримтлал үүсээд байгаа 2 цэг нь элсэрхэг хөрстэй, ургамлын дэгнүүл салхины нөлөөгөөр элсэнд хучигдсан, хөрсний ялзмагт үе элсэнд дарагдсан, өнгөн үе элсэрхэг болсон, элс хамарлаж тогтсон байдалтай байна. Тус талбайн хөрс нь хөнгөн элсэрхэг учир малын хөлөөр талхлагдаж, салхины нөлөөгөөр элс нүүдлэн шилжиж байна.

Хорголжин тэжээлийн дээж шинжлүүлэх тухай: Сумдын аюулгүйн нөөцөд 3 жил хадгалагдаж байгаа хорголжин тэжээлийн дээжийг 13 сумаас авч Улсын мал эмнэлэгийн төв лабораторид хүнд металын үлдэгдэл, мөөгөнцөрийг шинжлүүлэхээр хүргүүллээ. Тус шинжилгээний хариуг үндэслэн хорголжин тэжээлийг малын тэжээлд цаашид ашиглаж болох эсэхийг шийдвэрлэнэ.

Цахим сургалтанд хамрагдлаа: “Парисын хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт (NDC)-ын хэрэгжилтийг хөдөө аж ахуй, газар ашиглалтын салбарт ил тод байдлаар тайлагнах, мониторингийн үндэсний чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд **“ПАРИСЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛСЫН ХААОБГА-ЫН САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ”** цуврал цахим сургалтанд хамрагдсан.

Ноолуурын урамшуулал олгож эхлэв: Монгол Улсын Засгийн газар ноолуурын үнийн уналтаас хамгаалах, үндэсний үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр хангах, малчидын амжиргааны түвшинг бууруулахгүй байх, экспортыг дэмжих зорилгоор “Ноолуурын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 101 дүгээр тогтоолын хүрээнд 2019 оны А-дансандаа ямаа тоолуулсан малчин, мал бүхий өрхөд ноолуурын урамшууллыг 1 ямаанаас дунджаар 300 гр ноолуураар тооцож, 1 кг тутамд 20,000 төгрөгийн урамшууллыг овог, нэр, регистрийн дугаар, дансны тулгалт хийсэн малчдын дансанд олгож эхлээд байна. Аймгийн хэмжээнд 14 сумын 6026 малчинд урамшуулал олгогдоно. Овог, нэр, регистрийн дугаар, дансны мэдээлэл зөрүүтэй өрхийн мэдээллийг залруулах ажил хийгдэж байна.

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Загсийн газраас баталсан холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэв. **Үүнд :**

Тайлант хугацаанд хүний нөөцийн болон үндсэн үйл ажиллагааны тушаал 1-ийг боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллагаас ирсэн-29, явсан-25 албан бичиг үүнээс хариутай 10 албан бичигт бүртгэл хөтлөн холбогдох албан тушаалтанд хүргүүлж, шийдвэрлэсэн 5, хугацаа болоогүй 5-н албан бичиг байна.

Тус хугацаанд аж ахуй нэгж байгууллага болон хувь хүн төрийн байгууллагаас нээлтэй утас 70583370 дугаарт болон бичгээр ирсэн өргөдөл, гомдол хүлээн аваагүй байна.

Биокомбинат УТҮГ-тай 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан 2020/01/17 дугаартай гэрээний дагуу аймгийн хэмжээнд шаардагдах 1 нэр төрлийн мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 49,913,437 төгрөгийн үнэ бүхий вакцин татан авахаас 7 нэр төрлийн 27,597,621 төгрөгийн үнэ бүхий вакцин татан авч нийлүүлэлт **68,9** хувийн гүйцэтгэлтэй байна.

МАЛ ЭМНЭЛГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 225, 43 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 01 албан даалгавар, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 02 удирдамж, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/34, 63 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны А/194, 195, 122 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Баянтүмэн, Матад Чулуунхороот сумдад хяналт шалгалт хийж ажилласан.

Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчний гаралт, дархлаажуулалтын байдал:

Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 2020 оны эхний ээлжийн дархлаажуулалтанд 2,0 сая толгой мал сүрэг хамруулахаас 1,5 сая толгойг хамруулж 78 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Хөлөнбуйр сумын 1-р багт дотрын халдварт хордлого, Дашбалбар сумын Харзат багт бог малд цусан халдварт өвчнүүд оношлогдож, САЗ-ын дагуу тэмцэх арга хэмжээг зохион байгуулан ажилласан.

Газрын даргын А/12 тоот тушаалын дагуу мал, амьтны зооноз халдварт боом өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 290,0 мянган толгой бод, бог малыг хамруулах ажлыг 2020 оны 6 дугаар сарын 15-ны дотор зохион байгуулахаар 14 сумдын МЭТ-ийг чиглэлээр хангаж ажилласан.

Орон нутгаас санхүүжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд 365,900 толгой мал, амьтан хамрагдахаас 97,267 толгой мал, амьтан хамрагдаж 26,6 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Халхгол, Дашбалбар, Чойбалсан, Баяндун, Хэрлэн, Булган, Хөлөнбуйр сумдаас онош тогтоох зорилгоор ирүүлсэн дээжинд стандарт аргазүйн дагуу оношлогоо шинжилгээг хийж гүйцэтгэж Хөлөнбуйр сумын 1-р багт дотрын халдварт хордлого, Дашбалбар сумын Харзат багт бог малд цусан халдварт өвчнүүд оношлогдсон.

Халхгол сумын Дэгээ голын засталаас ирүүлсэн галзуу өвчний дээж, Чойбалсан сумын Хар нуур, Цагаан нуурын засталаас ирүүлсэн бог малын дээж, Баяндун сумын 1 дүгээр баг Цагаан хошуу гэдэг газраас ирүүлсэн дээжнүүдэд МЭАЦЛ-ийн шинжилгээний дүнгээр халдварт өвчин оношлогдоогүй.

УМЭАЦТЛ-ийн захирлын 2020 оны 03 сарын 20-ний өдрийн А/16 дугаар тушаал, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн захирал, аймгийн Мал эмнэлгийн газрын дарга нарын хамтарсан гэрээ удирдамжийн дагуу тус аймгийн

Хөлөнбуйр, Баян-Уул, Баяндун, Сэргэлэн сумдын шүлхий өвчинд мэдрэмтгий мал сүрэгт шүлхий өвчний байгалийн халдвар илрүүлэх тандалтын ажлыг 2020 оны 04 дүгээр сарын 28-ний өдрөөс эхлэн 8 хоногийн хугацаанд эпидмиологийн тооцооллоор сум тус бүрээс 8 өрх, 1 өрхөөс 6-12 сартай 5 толгой бяруу, 5 толгой төлөг, борлон нийт 4 сумын 32 өрхийн 480 толгой малаас цусны дээж, асуумж авч тусгай аппликешнд бүртгэн ажилласан. Нийт цуглуулсан ийлдсийн дээжинд Шүлхийн вирусн ББУ-ийн эсрэгбием илрүүлэх ЕЛИЗА (ID Screen®FMD NSP competition, IDvet) оношлуураар УМЭАЦТЛ-ийн шинжээч эмч нарын заавар зөвлөмжийн дагуу аймгийн МЭАЦЛ-т шинжилгээг хийж гүйцэтгэнэ.

Орон нутгийн “Нутаг 21” телевизтэй хамтран 2019 оны гоц халдварт өвчний ажлын гүйцэтгэл, 2020 оны гоц халдварт өвчнөөс сэргийлэх үйл ажиллагаа, цаашдын зорилт сэдвээр олон нийтэд мэдээлэл хүргэж ажилласан.

МЭЕГ-ын даргын 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/99 тоот тушаалын дагуу аймгийн Мал эмнэлгийн газарт хуваарилсан яаралтай тусламж үйлчилгээний зориулалтаар ашиглах “Лада” Нива Урбан маркын автомашин 1, сумдын мал эмнэлгийн тасгийн үйл ажиллагаа, чадавхийг сайжруулах зорилгоор 12 компьютер, 8 принтер, тумбочиктай бичгийн ширээ, сандал, шуурхай ажил үйлчилгээнд зориулж 14 ширхэг мотоцикл, 36 ширхэг зөөврийн хөргүүр хүргүүлснийг Захиргаа, санхүүгийн алба хүлээн авч санхүүгийн программд бүртгэлжүүлэн 14 сумын МЭТ-т хуваарилан олгосон.

Мал эмнэлгийн ерөнхий газраас өгсөн үүрэг, чиглэл, даалгаврын дагуу газрын албан хаагчдыг өндөржүүлсэн бэлэн байдлын үед хариуцлагатай жижүүр хийх хуваарийг боловсруулж, албан хаагчдыг 08-17 цагийн хооронд хийж гүйцэтгүүлж, МЭЕГ-ын хариуцлагатай жижүүрт цаг үеийн байдлаар мэдээлэл өгч ажиллаж байн

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ЧИГЛЭЛР:

Энэ онд аймгийн хэмжээнд ХХААХҮЯамны сайд, Аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүний нийлүүлэх гэрээгээр 22,6 мянган.га-д үр тариа, үүнээс 18,5 мянган.га-д улаан буудай, 4,5 мянган га-д тосны ургамал, 2,5 мянган.гад малын тэжээл 161 га-д төмс, 117 га-д хүнсний ногоо тариалж, үр тарианы ургац 27,0 мянган.тн, үүнээс 22,2 мянган тн улаан буудай, 4,8 мянган тн бусад үр тариа, 3,6 мянган.тн тосны ургамал, 1,9 мянган.тн төмс, 1,4 мянган.тн хүнсний ногооны ургац хураан авахаар төлөвлөөд байна .

2020 оны 05 дугаар сарын 28 өдрийн байдлаар 12,0 мянган га-д тариалалт хийгдэж үүний 95,9 хувийг улаан буудайн тариалалт эзэлж байна.

Хүнсний ногооны үр олгосон тухай: Газар тариалангийн салбарт “Өрх бүр хүнсээ бэлтгэе” уриалга дор Аймгийн ИТХурлын 2017 оны 06 хуралдааны 03 тогтоолоор батлагдсан “Хүнсний ногоо” дэд хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2020 оны А/263 тоот захирамжаар Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5,8 сая төгрөгийн 22,7 га-д талбайд тариалах 6 нэр төрлийн хүнсний ногооны үрийг, судалгаанд хамрагдсан 800 гаруй өрхийн тариалан эрхлэгчдэд олгоод байна.

Мөн ХХААХҮЯамны Сайдын 2020 оны 05 сарын 15 өдрийн А/171 тоот тушаалаар 11 төрлийн 28,7 га-д тариалах 7,9 сая, төгрөгийн хүнсний ногооны үрийг хүлээн авлаа.

Нийлэг хальсан хүлэмж олгосон тухай: Монгол улсын Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 6 дугаар хуралдааны 3 дугаар тогтоолоор баталсан “Хүнсний ногоо” дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвийн 40.0 сая төгрөгийн хөрөнгөөр Дорнод аймгийн Баянтүмэн, Хэрлэн суманд тус бүр 4х8 хэмжээтэй 15 хүлэмжийг олгосон.

Үүний үр дүнд 32 м2 талбай бүхий 30 хүлэмжид тариалалт хийх нөхцөл бүрдэж хамгаалагдсан хөрсний ногооны аж ахуйн тариалалт 960 м2 талбайгаар нэмэгдлээ.

ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Хүнсний бүтээгдэхүүний үнэ: 2020 оны 01 сарын 28-ны өдрөөс 2020 оны 05 дугаар 30-ны өдрийг хүртэл хүнсний 19 нэр төрлийн бүтээгдэхүүний үнийг 8 цэгээс авч 7 хоног бүрийн пүрэв гарагт ЗДТГ-т хүргүүлж ажилласан.

Хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгаа: Хүнсний бараа бүтээгдэхүүний үйлдвэр, худалдаан дахь үлдэгдлийн судалгаа, нөөцийн мэдээ болон гамшгийн үеийн 100 хоногийн хүнсний бүтээгдэхүүний судалгааг 14 сумаас авч орон нутгийн хүн амын тоонд харьцуулан гаргаж 7 хоног бүрийн баасан гарагт ХХААХҮЯ-нд хүргүүлсэн.

Дэн буудлуудын үйл ажиллагаанд хяналт, шалгалтын ажил зохион байгуулсан талаар: Хэрлэн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нийт 9 Дэн буудлын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийхээс “Баян”, “Сод”, “Тулга”, “Амар”, “Билэг”, “Дорнын зэрэглээ”, “Арвин” гэсэн 7 дэн буудлын үйл ажиллагаанд нөхцөл байдлыг газар дээр нь шалгаж, үнэлэлт дүгнэлт хийж ажилласан.

Ажлын хэсгийн мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007 стандартын шаардлагын дагуу 75 үзүүлэлтээр 1-5 оноо өгч үнэлж, биелэлтийг хувиар гарган дүгнэсэн.

Эдгээр 7 дэн буудлаас 5 дэн буудал өмнө нь тохирлын үнэлгээнд хамрагдаж тохирлын гэрчилгээ авсан ба “Арвин” дэн буудалд стандарт, хэмжил зүйн хэлтсээс тодорхой үүрэг чиглэл өгч байсан боловч өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй байна. “Сод”, “Амар”, “Билэг”, “Баян” зэрэг буудлууд нь стандартын шаардлагыг хангаж байгаа хэдий ч мөн зарим нэг дутагдалтай зүйлсийг хийх шаардлагатай байна. “Тулга”, “Дорнын зэрэглээ”, “Арвин” зэрэг дэн буудлууд нь стандартын шаардлага хангагдаагүй үнэлэх боломжгүй байгаа тул үйл ажиллагааг зогсоож хязгаарлалтын дэглэм цуцлагдсан ч стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангуулж тохирлын гэрчилгээ авсны дараа үйл ажиллагааг хэвийн явуулах боломжтой гэж үзсэн. “Баян”, “Амар” дэн буудлуудад ажлын хэсгээс хугацаатай үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Орон тооны бус баталгаажуулалтын зөвлөлийн хурал: "Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль"-ийн 4 дүгээр бүлгийн 13, 14, 15 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоол, Стандарт, хэмжил зүйн газрын даргын "Баталгаажуулалтын шинжээчийн дүрэм батлах тухай" 2019 оны А/99 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус хэлтсийн бүтээгдэхүүний баталгаажуулалтын мэргэжилтэн шаардлага хангасан 21 аж ахуйн нэгжийн худалдаа, үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийж орон тооны бус Баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв. Аймгийн Засаг даргын 2020 оны А/172 дугаар захирамжаар байгуулагдсан хязгаарлалттай дэглэмийн үед хүн амыг хүнсний бүтээгдэхүүний хангах, тогтвортой байлгах, эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний нөөц бүрдүүлэх талаар хуралдсан. Хуралдаанаас А/172 дугаар захирамжид өөрчлөлт оруулж ажлын хэсгийг өргөтгөх болсон.

Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газрууд хамтарч төлөвлөгөөний төслийг боловсруулж байна.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Засгийн газрын 2020 оны 113 тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих” журмын дагуу төсөл хүлээн авах хугацааг

04 дүгээр сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 19-ний өдөр хүртэлх хугацаанд хүлээн авч, 9 чиглэлийн 2.6 тэрбум төгрөгийн 32 төслийг хүлээн аваад байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/320 дугаар захирамжаар төсөл сонгон шалгаруулах дэд хороог 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулаад байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Авилгатай тэмцэх газар, Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагатай хамтран “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор олгож байгаа санхүүжилтийн үйл ажиллагаанд нээлттэй, ил тод шударга байдлыг хангах нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Х.Бат-Эрдэнэ, мэргэжилтэн О.Энхжаргал, төсөл хөтөлбөрийн нэгжийн нарийн бичгийн дарга Т.Чимгээ, Э.Нандин-Эрдэнэ, Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж буй “BEST” төслийн ажилчид хамрагдаж, авилга ашиг сонирхлоос ангид байх талаар сургалтад хамрагдсан.

Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж буй “BEST” хөтөлбөртэй хамтран жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих” журмын танилцуулга, зээлийн батлан даалтын сангийн талаар мэдээлэл өгсөн.

Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн шаардлага хангасан 38 аж ахуйн нэгж, хоршоодод тодорхойлолтыг олгосон.

Ахуйн үйлчилгээний чиглэлээр 2016-2020 онд хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийг талаар мэдээллийг сумдаас авч нэгтгэсэн. Мөн аймгийн 14 сумын халуун усны төвийн судалгааг гаргасан.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох зээлтэй холбогдуулан сум хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 280 иргэн, аж ахуйн нэгжийн 1.4 тэрбум төгрөгийн зээлийн ангилалын мэдээг ХХААХҮЯ-нд хүргүүлсэн.

Түүхий эд бэлтгэлийн мэдээг 7 хоног бүрийн Пүрэв гарагт гаргаж, ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн газрын tuuhiied.2020@gmail.com цахим хаягаар хүргүүлэн ажиллаж байна.

Газрын харилцааны чиглэлээр:

Газрын кадастрын мэдээллийн санд 70 иргэн, аж ахуйн нэгжийн кадастрын зургийг мэдээллийн санд оруулж өөрчлөлт хийж, дундын мэдээллийн сангаар дамжуулж 10 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг илгээж гэрчилгээ олгож, гэрээ байгуулсан байна.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас 2017 оны 07 дугаар сараас эхлэн “БНХАУ-ын Байгалийн нөөцийн яамны Газрын хиймэл дагуулын алсын зайнаас тандан судлах төв”-тэй байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хэрэгжилтийн хүрээнд зохион байгуулсан БНХАУ-ын ZY-3 хиймэл дагуулын 2.1 метрийн нарийвчлалтай панхроматик, үзэгдэх гэрлийн 5.8 метрийн нарийвчлалтай сансрын зургийн тоон өгөгдлийг боловсруулах тухай цахим сургалтад холбогдох мэргэжилтнийг хамруулсан.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 186 дугаар зарлиг, УИХ-ын 2003 оны 42 дугаар тогтоолын дагуу Монгол орны газар зүйн нэрийн мэдээллийн сан байгуулах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2019 оны А/563 дугаар захирамжаар “Газарзүйн нэрийн салбар зөвлөл” байгуулан улмаар сумдад газар зүйн нэрийн дэд зөвлөлийг байгуулан ажиллаж байна. Дээрх ажлын хүрээнд Дашбалбар сумын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “газарзүйн нэрийн тодруулалт, нэрийн мэдээллийн сан байгуулах” ажлыг орон нутгийн сангийн хөрөнгөөр 10 000,0 төгрөгөөр хэрэгжүүлэхээр батлагдсаны дагуу ажлын даалгаврыг боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэгчээр “Оюу имиж” ХХК шалгараад байна.

Газрын төлбөрийн 2020 оноос өмнөх дутуу төлбөрийг нийт дүнгээр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт цахим нэхэмжлэх үүсгэхтэй холбогдуулан аймгийн хэмжээнд 2020 оноос өмнөх дутуу төлбөрийн тайлан, мөн 2020 оны газрын төлбөр ногдуулалтыг Татварын хэлтэст хүргүүлж ажиллалаа.

Барилга, хот байгуулалтын ажлын чиглэлээр:

2020 онд улс, орон нутгийн болон орон нутгийн хөгжлийн сан, авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх засвар үйлчилгээ, тохижилт, авто зам, барилга угсралтын чиглэлээр он дамжин хийгдэж буй 18 төсөл арга хэмжээ, энэ жил шинээр гэрээ байгуулсан 79 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтын ажлыг хийж гүйцэтгэж байна.

Орон нутгийн өмчийн газраас гэрээ байгуулах 79 дүгнэлт ирүүлсний дагуу гүйцэтгэгч компаниудтай 73 ажлын ажил гүйцэтгэх гэрээг байгуулан, 6 ажлын гэрээ байгуулах шатанд явж байна.

Орон нутгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар аймаг, сумдад хэрэгжиж буй барилга угсралт, инженерийн шугам сүлжээ, их засварын ажлуудад захиалагчийн хяналтын ажил гүйцэтгэн ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн сумын 1 болон 5 дугаар сургуулийн бага сургуулийн өргөтгөлийн барилгын ажлыг “ДОЦ” ХХК хийж гүйцэтгэж, 1 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилгын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй, 5 дугаар сургуулийн барилгын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй ажил явагдаж байна.

1-р сургуулийн өргөтгөлийн барилга

5-р сургуулийн өргөтгөлийн барилга

Баянтүмэн сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга болон Хэрлэн сумын 3-р багийн 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг 2019 оноод эхлэн “Талын сүлд” ХХК хийж гүйцэтгэж байна.

Хэрлэн сумын 7-р багийн нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Түүх соёл” ХХК нь Эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэж байна.

Хэрлэн сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт 640 хүүхдийн суудал бүхий сургуулийн барилгын ажлыг гүйцэтгэхээр “Шимт газар” ХХК шалгаран суурийн нүх ухах ажил хийгдсэн, суурийн ажлын бэлтгэл байдал хангагдаж байна.

“Сүхжин” ХХК-ийн хийж гүйцэтгэж байгаа Музейн барилгын суурийн ажил хийгдэж байна. Тус барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хамт хяналтын ажлыг хийж гүйцэтгэж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баян-Уул сумын 250 хүний суудал бүхий соёлын төвийн барилга угсралтын ажлыг “Дорнын-Оч” ХХК, Гурванзагал сумын соёлын төвийн барилга угсралтын ажлыг “ЦОДММ” ХХК, Матад сумын соёлын төвийн барилгыг “Хөвсгөл геологи” ХХК хийж гүйцэтгэж байна